



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/194

Ховд

Хөл хорионы дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Жаргалант сумыг бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /улаан түвшин/, бусад хөдөөгийн сумдыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /улбар шар түвшин/ 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд шилжүүлсүгэй.

2.Захирамжийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/184 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ